



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРААР ҮЙЛЧЛҮҮЛЖ БУЙ ИРГЭДЭЭС 2025 ОНЫ IV-Р УЛИРАЛД АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын Нэг цэгийн үйлчилгээний тасагт иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.




СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Асуумж1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал:




Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 308 иргэдийн насны хувьд авч үзвэл 25 хүртэлх насны 40 иргэн буюу 11.5%, 25-34 насны 41 иргэн буюу 13.3% , 35-44 насны 106 иргэн буюу 34.4%, 45-54 насны 46 иргэн буюу 14.9% , 55-с дээш насны 75 иргэн буюу 24.4% тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.


Асуумж2:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс:



Дүгнэлт: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс 4-р улирлын сэтгэл ханамжийн судалгаанд 308 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 190 иргэн буюу 61.7% эмэгтэй, 118 иргэн буюу 38.3% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.

**Асуумж3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн боловсролын байдал:**


Дүгнэлт: Судалгаанд оролцсон 308 иргэдийн боловсролын байдлыг үнэлэхэд боловсролгүй 1 иргэн буюу 0.3%, бага боловсролтой 10 иргэн буюу 3.2%, бүрэн дунд боловсролтой 211 иргэн буюу 68.5%, дээд боловсролтой 86 иргэн буюу 27.9%-ийг тус бүр эзэлж байна.

Асуумж4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн авч буй үйлчилгээний төрөл:

Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ авсан төрлийг үнэлэхэд бусад үйлчилгээг 37 иргэн буюу 12%, лавлагаа авсан 17 иргэн буюу 5.5%, сайн дурын даатгалын гэрээ байгуулсан, төлөлт хийсэн 73 иргэн буюу 23.7%, шимтгэл төлөлтийн тайлан өгсөн 3 иргэн буюу 1.5%, тэтгэвэр тогтоолгох материал өгсөн 87 иргэн буюу 28.2%, тэтгэмж тогтоолгох материал өгсөн 91 иргэн буюу 29.5% тус тус үйлчилгээ авсан байна.




Асуумж5: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн байгууллагын албан хаагчаас мэдээллээ бүрэн авсан байдал:




Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 308 иргэнээс “Хангалттай” гэсэн үнэлгээг 298 иргэн буюу 96.8% “Дунд зэрэг” үнэлгээг 10 иргэн буюу 3.2% тус тус үнэлсэн байна.

Асуумж7:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн албан хаагчтай хэдэн удаа уулзсан талаарх үнэлгээ?




Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 308 иргэдийн үйлчилгээ авахдаа албан хаагчтай 1 удаа уулзсан 251 иргэн буюу 81.5%, 2 удаа уулзсан 42 иргэн буюу 13.6%, 3 удаа уулзсан 7 иргэн буюу 2.3%, 4 удаа уулзсан 7 иргэн буюу 2.3%, 5 удаа уулзсан 1 иргэн буюу 0.3% тус бүр үнэлсэн байна.

Асуумж8: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн албан хаагчтай 3-аас дээш удаа уулзсан шалтгаан?




Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 308 иргэдээс 15 иргэн албан хаагчтай 3-аас дээш удаа уулзсан ба үүнээс 10 иргэн судалгаанд хариулсан байна. Үүнээс “Би өөрөө бичиг баримтаа дутуу бүрдүүлсэн” шалтгаанаар 9 иргэн буюу 2.9%, “Бусад” шалтгаанаар 1 иргэн буюу 0.3% тус бүр байна.

Асуумж9: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн албан хаагчдын харилцааны соёлын үнэлгээ?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчаас албан хаагчийн харилцааны соёлын үнэлгээ авахад “Хангалттай сайн” үнэлгээг 300 иргэн буюу 97.4%, “Сайжруулах шаардлагатай” үнэлгээг 8 иргэн буюу 2.6%-тай тус бүр үнэлсэн байна.


Асуумж11: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн байгууллагын орчин, тав тухтай байдлыг үнэлсэн үнэлгээ:






Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчаас байгууллагын орчин, тав тухтай байдлын үнэлгээ авахад “Хангалттай” гэж 284 иргэн буюу 92.2%, “Сайжруулах шаардлагатай” гэж 24 иргэн буюу 7.8%-тай тус бүр үнэлсэн байна.

Асуумж12: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн байгууллагын орчин, тав тухтай байдлын юуг сайжруулах шаардлагатай гэж үзэж байгааг үнэлсэн үнэлгээ:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 308 иргэдээс 24 иргэн орчин, тав тухтай байдлыг сайжруулах шаардлагатай гэж үзсэн ба үүнээс 18 иргэн яагаад сайжруулах шаардлагатай талаар судалгаанд хамрагдсанаас танхимын зохион байгуулалтыг өөрчлөх 9 иргэн буюу 2.9%, мэдээлэл хангалттай байршуулах 4 иргэн буюу 1.3%, гэрэлтүүлэг хангалттай биш 3 иргэн буюу 1.0%, бусад шалтгааныг сонгосон 2 иргэн буюу 0.6% тус бүр үнэлсэн байна.


Асуумж13: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн нийгмийн даатгалын сурталчилгаа, мэдээллийг авдаг төрөл:





Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдээс нийгмийн даатгалын талаарх сурталчилгаа, мэдээллийг хаанаас авдаг талаарх судалгаа авахад вэб хуудаснаас 50 иргэн буюу 16.2%, лавлах утаснаас 8 иргэн буюу 2.6%, байгууллага дээр биеэр ирж 31 иргэн буюу 10%, нийгмийн сүлжээгээр 168 иргэн 54.5%, огт авдаггүй 5 иргэн 1.6%, тараах материал, танилцуулгаас 8 иргэн буюу 2.6%, телевизээс 38 иргэн буюу 12.3% тус бүр мэдээллээ авдаг байна.

Асуумж14: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн нийгмийн даатгалын гар утасны аппликейшныг ашигладаг байдлын үнэлгээ:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчаас нийгмийн даатгалын гар утасны аппликейшныг ашигладаг талаарх судалгаа авахад 28 иргэн буюу 9.1% нь татаж авч чадаагүй, 36 иргэн буюу 11.7% нь тийм, 9 иргэн буюу 2.9% нь ухаалаг утас ашиглах боломжгүй, 235 иргэн буюу 76.3% нь үгүй гэж тус, тус өгсөн байна.

Асуумж15: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн нийгмийн даатгалын www.ndaatgal.mn вэб сайтын талаар мэдээлэл авч байсан байдлын үнэлгээ:





Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдээс нийгмийн даатгалын www.ndaatgal.mn вэб сайтын талаар мэдээлэл авч байсан талаарх судалгаа авахад 134 иргэн буюу 43.5% нь мэдэхгүй, 138 иргэн буюу 44.8% нь тийм, 36 иргэн буюу 11.7% нь хааяа гэж тус бүр үнэлсэн байна.



Судалгаанд оролцсон иргэд санал, хүсэлт өгөөгүй байна.

СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ ХИЙСЭН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН АХЛАХ ТӨЛӨӨЛӨГЧ: Н.ШҮРЭН-ЭРДЭНЭ